

Монгол улсын хүн ам, өрхийн бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлт

Д. Ганхуяг

Монгол Улсын Их Сургуулийн Хүн Ам

Зүйн Сургалт Судалгааны Төвийн дэд захирал

Монгол улс нь ази тивийн төвд оршдог, 1.566 сая км.кв газар нутагтай, 2.35 сая хүн амтай дэлхийн хамгийн сийрэг хүн амын нягтшилтай орнуудын нэг юм. Түүхэн цаг хугацаанд Монголын хүн амын бүтэц, бүрэлдэхүүн нь дэлхий нийтийн жишгийн дагуу тухайн үеийн нийгмийн тогтолцоо, эдийн засгийн хөгжлөөс хамааран байнга хувьсан өөрчлөгдөж ирсэн билээ. Хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтийн байдлаар авч үзэж байсан хандлагаас хүний хүчин зүйлсийн нөлөөлийг чухалчилдах явдал дэлхийд нийтлэг ажиглагдаж байгаа нь хүн амын үзэгдлийн шинж чанарын өөрчлөлтийн хандлага, хүн ам зүйн бодлогын ач холбогдлыг нэмэгдүүлэх болжээ.

Монголын хүн амын уламжлалт бодлого

Монгол улс нь дэлхий дээр хүн анх амьдарч байсан өлгий нутгийн нэг гэж эрдэмтэд үздэг билээ. Монгол орны газар нутагт анхны төрт улс тогтсон үе буюу одоогоос 2000 гаруй жилийг өмнөөс хүн амаа бүртгэх, тодорхой хүн амын бодлого баримтлах явдал эхлэлээ тавьжээ. Түүхийн энэ үеэс барьж ирсэн бодлого 12-р зуун, Чингэс хааны үеэс улам боловсронгуй болж, хүн амын албан татвар авах, цэргийн алба хаалгах, нутаг бэлчээр хувиарлах зэрэг зорилгын үүднээс хүн амаа аравт, зуут, мянгат, түмтийн зохион байгуулалтад оруулж бүртгэх тогтолцоог бий болгосон юм. Газар нутгийг бүрэн ашиглах зорилгоор суурьших нөхцөлийг ханган бүрдүүлэх, эзгүйрсэн нутгуудад хүн амыг нутагшуулах, өртөө улааны суурингууд байгуулах, нийслэл Хар Хорин хотыг үндэслэх зэрэг байршлын холбогдолтой бодлого голлон хэрэгжиж байлаа. Дэлхий нийтийн хүн ам зүйн түүхэн зүй тогтлын дагуу хөгжлийн ерөнхий түвшнээс хамааран энэ үед хүн амын ердийн өсөлт тун доогуур байсан ба ялангуяа 12-14-р зууны бараг дэлхийн талыг хамарсан их байлдан дагуулалтын үрээр олон тооны хүн ам бусад улс орнуудад суурьшин, аажмаар тухайн үндэстэнд ууссан нь Монголын хүн амын өсөлтийг бууруулсан нэг хүчин зүйл болсон юм.

Их гүрний доройтлыг даган 15-р зууны эхэн үеэс хүн амын цэгцтэй бодлого суларч, улмаар 17-р зууны сүүлчээр Монгол улс Манжийн эрхшээлд орсны дараа төрийн уламжлалт бодлого тасрахад хүрсэн билээ. Манж, хятадын эрх баригчид засаг захиргааны хуучин тогтолцоог өөрчлөн хошуудын хэлбэрт оруулснаар хүн амын байршил нутагшилтын зохистой

байдал алдагдснаас гадна, шарын шашин дэлгэрүүлснээр 18-р зууны эцэс гэхэд насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 1/3 нь лам болж, гэр бүл болоогүй эмэгтэйчүүдийн хувийн жин төдий хэмжээгээр нэмэгдэн, өрхийн бүтэц гажуудалд орон төрөлт туйлын доогуур түвшинд тогтож, хүн амын өсөлт зогссон байв. Мөн энэ хугацаанд эрүүл ахуйн байдал доройгоос хүн амын өвчлөл хэт нэмэгдэж, нас баралтын түвшин ихээхэн өндөр байсан нь хүн ам цөөрөх нөхцөл бож байлаа. Дээрх түүхэн үйл явцаас хамааран 20-р зууны эхэн хүртэлх 300 гаруй жилд Монголын хүн ам үндсэндээ 2 дахин багасч, 1918 оны тооллогоор гадаадын иргэдийг эс тооцвол 540000 хүн бүртгэгдсэн. Энэ үеэс дэлхий дахинд Монголыг мөхөж буй үндэстэн гэсэн ойлголт давамгайлах болсон билээ. Хүн амын өсөлтийн хурд сөрөг, өөрөөр хэлбэл нас баралтын түвшин төрөлтийн түвшнээс даван гарсан байсан нь дээрх үзлийн баталгаа болж байсан юм.

Хүн амын өсөлт өөрчлөлт

1921 оны хувьсгалын дараа үндэстэн мөхөх аюулаас аврагдсан хэдий ч 1950-иад оны дунд үеийг хүртэл хүн амын өсөлт тун доогуур түвшинд удаанаар хадгалагдаж байлаа. 1918-аас 1950 оны хооронд Монголын хүн ам 648.1-ээс 772.4 мянга болж, 124 мянгаар нэмэгдсэн ба хүн амын өсөлтийн жилийн дундаж хурд дөнгөж 0.6 хувь байв. Энэ үед нийгэм-эдийн засгийн хөгжлийн буурай түвшнээ дагаад эрүүлийг хамгаалах системийн байдал тун дорой байснаас хүн амын дунд өвчлөл өндөр, нас баралтын түвшин харьцангуй их байлаа. Мөн түүнчлэн 1930-аад оны улс төрийн хэлмэгдүүлэлт, 1939, 1945 онуудын дайн самуунууд зэрэг нийгэм, улс төрийн тогтворгүй нөхцөлүүд нь шууд болон шууд бус замаар төрөлтийн түвшинд сөргөөр нөлөөлж, хүн амын өсөлтийг хангахад ихээхэн саад учруулж байсан томоохон хүчин зүйлүүд болсон.

Дэлхийн 2-р дайны дараа олон хөгжиж буй улсууд тусгаар тогтнолоо зарлан, нийгэм-эдийн засгийн байдал нь харьцангуй тогтворжиж ирсэн нь хүн амын өсөлтөд ч нэгэн адил нөлөөлж, төрөлтийн түвшин огцом нэмэгдснээс гадна, хөгжингүй улс орнуудаас анагаах ухааны шинэ ололтууд, эрүүлийг хамгаалахын боловсон хүчин болон материаллаг туслалцааг шууд авах бололцоо нээгдсэн зэрэг нь эдгээр орнуудын хүн амын ерийн өсөлтийн хурд богино хугацаанд нь нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн билээ. Энэхүү нийтлэг хандлага Монголд ч гэсэн ажиглагдсан юм.

Хүснэгт 1: Хүн амын тоо, өсөлт 1918–1996 /мянган хүн, оны эцэст/		
Он	Хүн амын тоо	Өсөлтийн хувь
1918	648.1	—
1930	727.4	1.01
1940	743.8	0.15
1950	772.4	0.38
1960	968.1	2.28
1970	1265.4	2.78
1980	1682.0	2.89
1990	2149.3	2.48
1996	2353.3	1.58

1950–иад оны дунд үеэс улс төрийн тогтворжилтоо даган нийгэм эдийн засгийн өсөлтийн хурдац нэмэгдэх болсон нь нийгмийн бүх салбарт эерэг нөлөө үзүүлсэн билээ. Энэ нь цаашид хүн ам эрчимтэй өсөх сайхан хөрс болжээ. 1960–аад оноос 1980–аад оныг хүртэл Монголын хүн амын өсөлтийн хурд дээшилсээр бараг 3 хувь болсон нь дэлхийд дунджаас (1.9 хувь) нэлээд дээгүүр орох үзүүлэлт байлаа. Энэ үед амьжиргааны түвшний өсөлт нь улс орны хэмжээгээр төрөлт өндөр байх нөхцөлийг хангаж байснаас гадна, орчин үеийн анагаах ухааны салбар маш богино хугацаанд үсрэнгүй хөгжсөн нь нас баралт эрчимтэй буурах таатай бололцоог олгожээ. Хэдийгээр төрөөс төрөлтийг дэмжих, хүн амын өсөлтийг аль болох өндөр түвшинд барих хатуу бодлого явуулж байсан боловч нийгмийн нийтлэг хөгжлийн зүй тогтлын дагуу 1980–аад оноос төрөлтийн түвшин аажим буурч эхэлснээс хүн амын өсөлтийн хурдац багасах байдал үүсэн гарсан билээ.


1990–ээд оны социалист системийн орнуудыг хамарсан улс төр, нийгэм–эдийн засгийн тогтолцооны бүрэн өөрчлөлт нь Монголд нэгэн адил явагдсан бөгөөд зах зээлийн эдийн засагт шилжин, бараа бүтээгдэхүүний үнийн огцом өсөлт, инфляци, ажилгүйдэл зэрэг үзэгдэл нь улс оронд эдийн засгийн гүнзгий хямрал үүсгэн, өрх, хүн амын амьжиргаа доройтох үндэс болсон. Үүнийг дагаад 1986–1990 онд хүн амын өсөлтийн хурд 2.5 хувь байснаа 1990–1994 оны үед өсөлтийн хурд эрс бууран 1.5 хувьд хүрсэн ба харин сүүлийн 2 жилд төрөлтийн түвшин бага зэрэг нэмэгдэж, өсөлтийн хурдац 1.6–д тогтворжих хандлага ажиглагдаж байна. 1996 онд хүн амын өсөлтийн хурд 1.5 хувь байсан ба үүнийг аймгийн ялгавартай байдлаар авч үзэхэд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд, Баян–Өлгий, Хэнтий, Ховд аймгуудад улсын дунджаас өндөр байна. Мөн үед эдгээр хотуудад 1000 хүнд ноогдох төрөлт улсын дунджаас 2–5

пунктээр доогуур байгаагаас харахад хотуудын хүн амын өсөлт нь ердийн хөдөлгөөнөөр бус харин шилжин ирэгсдийн хэмжээнээс шалтгаалан бусад бүсээс харьцангуй өндөр гарсан нь тодорхой байна.


Эцэст нь дүгнэхэд 1950–1996 оны хооронд Монгол улсын хүн ам 772.4 мянгаас 2353.3 мянга болон 3 дахин нэмэгдсэн нь түүхэнд хамгийн богино хугацаанд хүн амаа эрчимтэй өсгөж чадсан бахархал болох үзүүлэлт юм.

Хүн амын насны бүтэц


Тухайн хүн амын насны бүтцийн хэв маяг нь хүн амын нөхөн үржихүйн цаашдын хандлагыг тодорхойлохоос гадна улс орны эдийн засгийн нэг гол хөшүүрэг болох ажиллах хүчний түвшин, төлөвийг харуулдаг тун чухал үзүүлэлт юм. 1920–иод оныг хүртэл удаан хугацаагаар хүн амын өсөлт зогсонги байснаас Монголын хүн амын насны бүтэц нь дэвшилтэд бус хэлбэртэй болсон байв.



Энэ нь 1950–иад оны дунд үеийг хүртэл хадгалагдсан бөгөөд төрөлт эрчимтэй нэмэгдэж эхэлсэн нь хүн ам залуужих, насны бүтэц тохиромжит хэлбэрт шилжих бололцоог олгосон билээ. 1950–иад онд Монголын хүн амын насны голч бараг 30 наснаас 20 гаруйхан жилийн дотор эрс багасаж, 1979 онд хүн амын тал хувийг 18–аас доош насны хүүхдүүд эзлэх болжээ. Харин төрөлтийн түвшин буурснаас шалтгаалан энэ үзүүлэлт эргэн аажим өсөж, 1996 онд хүн амын голч нас 20.9 болсон байна.



Насны бүлгээр авч үзвэл, 1956 онд 0-14 насны хүн ам 30.4 хувийг эзэлж байсан бол 1979 онд 44.2 хувь эзлэх болсон нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд 1996 оны байдлаар 37.3 байгаа нь дэлхийн хэмжээнд залуу хүн амтай орны тоонд багтах юм. Хөдөлмөрийн насны буюу 15-64 насны хүн ам 1956 оноос 1980-аад оныг хүртэл аажим буурч байснаа (63.4-50.8) эргэн нэмэгдэж байгаа нь 1960-1980-аад оны өндөр төрөлтийн үеийн хүн ам хөдөлмөрийн насанд шилжин орох болсноор тайлбарлагдана. 1996 онд 15-64 насны хүн ам нийт хүн амын бараг 60 хувийг эзлэх болжээ. Харин өндөр настны хувьд 1956 оноос хойш хүн амд эзлэх хувийн жин тасралтгүй аажмаар багассаар, 1956 онд 6.2 хувиас 1996 онд 3.8 хувь болжээ. Гэхдээ хүн амын бүтцийн ерөнхий зүй тогтлоор энэ хувь ойрын ирээдүйд аажим нэмэгдэх байдал ажиглагдах болно.



Хөдөлмөрийн нөөц 1956 оноос хойш 3.2 дахин нэмэгдэж, 1996 оны байдлаар 1383.4 мянган хөдөлмөрийн насны хүн амтай байна. Хүн ам зүйн ачаалал буюу 100 тэжээгч насны хүн амд ноогдох тэжээлгэгч насны хүн амын тоо 1969 онд 101.8 байснаа буурсаар 1996 онд энэ үзүүлэлт 69.6 болжээ.

Хүйсийн бүтэц

Дэлхийн зарим оронтой харьцуулахад Монгол нь хүйсийн харьцаа харьцангуй урт хугацаанд тогтвортой, зөв хэлбэрт байгаа улсын тоонд багтдаг нь энэ зууны сүүлийн хагасаас хүйсийн харьцаа ноцтой алдагдах нийгэм, улс төр, хүн ам зүйн үзэгдэлд өртөөгүйн илэрхийлэл юм.

Хүснэгт 2: Хүн амын хүйсийн харьцаа, тооллогоор, 1994 оноор					
Үзүүлэлт	1956	1969	1979	1989	1996
Эрэгтэйчүүдийн эзлэх хувь	49.7	49.9	49.8	50.1	49.6
Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	50.3	50.1	50.2	49.9	50.4
Хүйсийн харьцаа	98.8	99.6	99.2	100.4	98.4

Хэдийгээр төрөх үеийн хүйсийн харьцаа дэлхийн дунджийн дагуу 100 эмэгтэй хүүхдэд ойролцоогоор 104 эрэгтэй хүүхэд ноогддог боловч эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин эмэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байдаг нь хүйсийн харьцаа 100 орчимд хэлбэлзэх нөхцөл болсон билээ.

Өрхийн бүтэц, бүрэлдэхүүн


Монголчууд эртнээс гэр бүл өрхийн уламжлалт ёс, хэлбэрийг чанд баримталж ирсэн билээ. Харин 18-р зууны үеэс шарын шашин дэлгэрч, олонхи эрэгтэйчүүд лам болон хүрээ хийдэд шавилан суун гэр бүлийн амьдралаас хөндий байх болсноос монголчуудын гэр бүлийн хэвийн бүтэц ихээхэн алдагдаж, улмаар нийгэмд орших ердийн үзэгдэл мэт ойлгох сэтгэлгээг бий болгожээ. Тухайлбал энэ зууны эхэнд насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 1/3 лам болон гэр бүлгүй амьдарч, ихэнх айл өрхүүд 1-2 хүүхэдтэй байх явдал түгээмэл ажиглагдаж байсан.

1930-аад оны цэргийн алба, татвараас чөлөөлөх буруу бодлогын уршгаар лам нарын тоо бараг 2 дахин нэмэгдэж 120000-д хүрсэн, нийгмийн ангиар ялгаварлан устгах, улс төрийн хэлмэгдүүлэлт өргөн хүрээтэй явуулах болсноор 10 гаруй жилд 15 мянган эрчүүд амь үрэгдэн нөхөргүй,

гэр бүл болоогүй, бэлэвсэн эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн. 1935–1947 онуудад 80 мянган эрчүүд цэрэгт урт хугацаагаар алба хааж байсан нь дээрх байдлыг улам дортгох үндэс болжээ.

1950–иад оноос гэр бүлийг бэхжүүлэх, гэр бүл болоогүй хүмүүсийн хувийн жинг бууруулах, хүн амын өсөлтийг дэмжих эрчимтэй бодлогыг нийгэм–эдийн засгийн арга хэмжээнүүдээр дамжуулан хэрэгжүүлж эхэлсэн нь өрхийн бүтэц тохиромжит хэв маягт шилжих таатай нөхцөлийг бүрдүүллээ. Үүний дүнд 1963 оны тооллогоор нийт өрхийн дунд 4–өөс дээш хүнтэй өрхийн эзлэх хувь 60 болж эрс нэмэгдсэн байна. Өрхийн дундаж хүн ам 4.3 байсан ба төрөлтийн өсөлттэй уялдан аажим нэмэгдсээр 1979 онд 5.1, харин 1989 онд эргэн буурч 4.8 болсон байсан нь өрх бүрэлдэх явц хүн ам зүйн ерөнхий зүй тогтлын дагуу явагдсан нь тодорхой байна.

1990–ээд онд Монголд гэр бүлийн хэв маяг, өрх бүрэлдэх үйл явцад хөндлөнгийн нийгэм–эдийн засгийн тодорхой бодлого, үйл ажиллагаануудаас шалтгаалан зүй тогтолт бус өөрчлөлтүүд нэлээд гарсан билээ. Эдийн засгийн хямралаас үүдэн хүнсний хэд хэдэн гол нэрийн барааг өрхөөр хувиарлан олгож, мөн мал хувьчлал явагдан, өрхөд ноогдуулан мал ноогдуулж байсан зэргээс 1990–ээс 1992 онд 20000 гаруй шинэ гэр бүл бий болсон байхад өрхийн тоо энэ хугацаанд харин 67 мянгаар огцом зохиомлоор нэмэгдсэн байна. Дээрх эдийн засгийн арга хэмжээнүүд зогсны дараа өрх эргэн нэгдэх үйл явц ажиглагдан, өрхийн тоо 509 мянга болж, 1992 оныхоос 10 орчим мянгаар цөөрчээ.



Сүүлийн 2 жилд өрхийн бүтцэд гарсан нэг өөрчлөлт бол эмэгтэйчүүд толгойлсон өрхийн хувийн жин улсын хэмжээгээр 4 хувиар нэмэгдсэн явдал юм. Харин судалгаанаас үзэхэд 1996 онд хөдөөд энэ үзүүлэлт 12.2 хувь буюу 1994 оныхоос даруй 8 хувиар нэмэгдсэн байна. Үүний гол шалтгаан нь засгийн газар болон олон улсын байгууллагууд, олон нийтийн байгууллагуудаас өрх толгойлсон эмэгтэйчүүдэд онцгой анхаарал хандуулан, тэдэнд хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, нийгмийн янз бүрийн хөнгөлөлт, тэтгэлэг олгох болсонтой холбоотой юм. Энэ үйл ажиллагаа ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүдэд илүү чиглэж байсан тул бэлэвсэн буюу салсан, хүүгээрээ өрхөө овоглож байсан эмэгтэйчүүд өрхөө өөрөөрөө овоглох, эцэг эхтэйгээ хамт амьдарч байсан эмэгтэйчүүд өрх салан тусгаарлах зэрэг үзэгдэл нэлээд түгээмэл болсон. Өрхийн тэргүүлэгчийн дундаж нас аймгийн төв, Улаанбаатар хотод 1994 оноос хойш 2 насаар нэмэгдсэн нь зүй тогтолт үзэгдэл юм. Харин хөдөөд энэ үзүүлэлт 5 насаар ахисан нь энд хүн ам зүйн ерөнхий тогтоцоос гадуур хөндлөнгийн хүчин зүйл нөлөөлж өрхийн тэргүүний дундаж нас зохиомлоор өссөн болохыг харуулж, дээр дурдснаар эмэгтэйчүүд толгойлсон өрхийн тоо үнэхээр нэмэгдснийг баталж байна.

Ашигласан материал:

- ХАБХЯ " Хүн ам ба хөгжил " үндэсний илтгэл 1995, УБ
- ХАЗССТ, МУИС " Монголын ХАЗ-н судалгаа " 1996, УБ
- ХАЗССТ, МУИС " Монголын ХАЗ-н судалгаа " 1996, УБ
- УСГ " Монгол улсын нийгэм эдийн засгийн байдал " 1994, УБ
- УСГ " Монгол улсын нийгэм эдийн засгийн байдал " 1994, УБ

